



БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

وَاللَّهُمَّ
صَلِّ عَلَى
مَنْ بَدَأَ
الْحَمْدَ

БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬ БОЛОН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛАХ ТӨЛБӨРИЙН ОРЛОГЫН ХЭСГИЙГ БҮРДҮҮЛЭХ, ЗАРЦУУЛАХ, ТАЙЛАГНАХ ЖУРМЫН 2022 ОНЫ ХЭРЭГЖИЛТ



ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД
АУДИТЫН ГАЗАР



БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬ


Байгалийн нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээ:



50% ≤



15% ≤



85% ≤



35% ≥



15% ≤

Тулгуур зарчим:

Байгалийн нөөц ашиглагч нь тухайн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх зардлыг төлөх

Зохицуулах харилцаа:

- Байгалийн нөөц ашигласны төлбөрийг ногдуулах, түүнийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх, тайлагнах
- Төлбөрийн орлогоос тухайн төсвийн жилд БОХНСАХ-нд зарцуулах хөрөнгийн хувь хэмжээг тогтоох
- Төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх, зөрчигчид хариуцлага хүлээлгэх

Дагалдах эрх зүйн акт:

2022 оны ЗГ-ын 02 дугаар тогтоолоор “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журмыг шинэчлэн баталсан.



БНАТ орлого ба БОХНСАХ-ний зардлыг төлөвлөх, батлах үйл явц

Төлөвлөхөд оролцогчид


Сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч

Байгаль хамгаалагч


Усны сав газрын захиргаа

Сум дундын ойн анги

ТХГН-ний захиргаа



Байгалийн нөөц ашигласны төлбөрийн 2022 оны орлого




Эх сурвалж: СЯ, Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн 2022 оны тайлан




БНАТ-ын 2022 оны орлогын гүйцэтгэл ангилал

№	Аймгийн нэр	Газар	Ойн нөөц	Ан, амьтны нөөц	Усны нөөц	Ургамлын нөөц	Нийт
		(сая.төг)					
1	Архангай	273.5	2,061.80	216.3	169.2	1.6	2,722.40
2	Баян-Өлгий	205.9	59.2	1,637.80	12.5	-	1,915.40
3	Баянхонгор	377.1	0.5	4,556.50	522.6	-	5,456.70
4	Булган	852.5	531.3	45.6	18,313.90	412.5	20,155.80
5	Говь-Алтай	456.1	2.2	368.8	128.7	0.2	956.00
6	Говьсүмбэр	278.4	-	-	367.2	-	645.60
7	Дархан-Уул	1,721.70	35.3	-	515.8	4.2	2,277.00
8	Дорноговь	7,412.50	-	644.7	705.3	-	8,762.50
9	Дорнод	1,267.70	42.3	-	3,212.80	-	4,522.80
10	Дундговь	529.6	0.1	650.6	400.8	-	1,581.10
11	Завхан	596.8	363.8	1,872.40	286.4	5.8	3,125.20
12	Орхон	23,107.60	20.1	-	328.7	-	23,456.40
13	Өвөрхангай	755.7	713.9	2,483.30	443.5	-	4,396.40
14	Өмнөговь	11,769.90	-	821.8	18,606.90	2.6	31,201.20
15	Сүхбаатар	309.5	-	1,366.30	603.1	56.1	2,335.00
16	Сэлэнгэ	1,413.90	5,201.60	19.7	1,461.80	2,875.80	10,972.80
17	Төв	3,191.40	2,882.90	1,572.00	1,652.20	89	9,387.50
18	Увс	561.6	169.8	614.8	44.4	0.1	1,390.70
19	Улаанбаатар	72,569.30	19.2	0	2,515.40	-	75,103.90
20	Ховд	915.8	0	1,492.20	175.9	33.2	2,617.10
21	Хөвсгөл	501.2	4,982.90	424.9	62.3	25.2	5,996.50
22	Хэнтий	872.7	1,541.80	1,543.50	915.8	-	4,873.80
Нийт		129,940.40	18,628.70	20,331.20	51,445.20	3,506.30	223,851.80
Уурь		58.1%	3.2%	8.1%	21.9%	1.6%	100.0%

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого 2018-2022 он




БНАТ 2022 оны нийт 223.8 тэрбум төгрөг төвлөрснөөс 47.9 тэрбум төгрөг давсан орлого байсан бөгөөд төлөвлөгөөний гүйцэтгэлийн орлого 175.9 тэрбум төгрөг байна.



Он	Газрын төлбөр	Усны нөөцийн төлбөр	Ан, амьтны нөөцийн төлбөр	Ойн нөөц ашигласны төлбөр	Байгалийн ургамлын нөөцийн төлбөр	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын нийт дүн
	(сая.төг)					
2018 он	18,675.50	46,692.40	5,847.70	4,072.20	502.6	75,729.60
2019 он	35,699.00	47,137.10	7,227.30	3,608.90	198.5	93,870.80
2020 он	49,468.50	42,151.50	1,164.10	12,279.00	7,066.20	112,129.30
2021 он	69,884.20	48,159.10	13,772.30	14,178.00	3,913.80	149,907.50
2022 он	129,940.40	51,445.20	20,331.20	18,628.70	3,506.30	223,851.80





Байгалийн нөөц ашигласны төлбөрийн 2022 оны орлогын зарцуулалт



Байгалийн нөөц ашигласны төлбөрийн 2022 оны орлогын зарцуулалт

№	Аймаг Нийслэл	2021 оны давсан орлого	2022 оны төлөвлөгөө	Нийт	Хуулийн дагуу зарцуулбал зохих доод хэмжээ	СЯ-ны мэдээгээр БНАТ зарцуулсан гүйцэтгэл	Хуулийн хэрэгжилт хувь
1	Архангай	1,240.16	795.1	2,035.26	1,261.31	1,010.50	80.1
2	Баян-Өлгий	523.52	558.4	1,081.92	481.56	171	35.5
3	Баянхонгор	1,826.43	1,079.70	2,906.13	1,135.04	818.7	72.1
4	Булган	3,763.16	15,895.80	19,658.96	7,088.95	3,776.00	53.3
5	Говь-Алтай	130.36	584.8	715.16	178.66	47.2	26.4
6	Говьсүмбэр	304.07	645.6	949.67	274.28	133.7	48.7
7	Дархан-Уул	66.03	2,053.10	2,119.13	490.89	312.6	63.7
8	Дорноговь	383.93	4,140.00	4,523.93	878.83	817.8	93.1
9	Дорнод	62.02	4,255.10	4,317.12	1,349.93	848.3	62.8
10	Дундговь	808.23	660	1,468.23	525.18	110.9	21.1
11	Завхан	1,068.65	1,162.20	2,230.85	957.81	608.6	63.5
12	Орхон	49.83	21,348.70	21,398.53	3,308.11	1,107.60	33.5
13	Өвөрхангай	2,473.00	1,725.70	4,198.70	2,031.02	1,494.50	73.6
14	Өмнөговь	371.63	30,269.90	30,641.53	8,422.30	6,495.30	77.1
15	Сүхбаатар	1,120.36	869.5	1,989.86	771.81	752.2	97.5
16	Сэлэнгэ	7,819.48	3,619.70	11,439.18	6,428.34	1,140.90	17.7
17	Төв	2,343.07	5,163.60	7,506.67	2,964.08	620.7	20.9
18	Увс	592.37	701.6	1,293.97	516.66	559.1	108.2
19	Улаанбаатар	-	75,103.91	75,103.91	11,782.11	2,011.30	17.1
20	Ховд	1,334.81	1,275.90	2,610.71	1,091.22	346.7	31.8
21	Хөвсгөл	2,069.20	1,885.20	3,954.40	2,794.95	830.5	29.7
22	Хэнтий	3,255.52	2,130.00	5,385.52	2,566.45	637.1	24.8
	Нийт	31,605.80	175,923.50	207,529.30	57,299.40	24,651.20	43

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийн хувь




№	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого, зарцуулалт	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он
		(сая.төг)				
1	Төлбөрийн нийт орлого	75,729.60	93,870.80	112,129.30	149,907.50	207,529.30
2	Хуулийн дагуу зарцуулбал зохих доод хэмжээ	25,604.40	28,563.90	34,252.40	46,862.90	57,299.40
3	Сангийн яамны зарцуулах эрх олгосон хувь, хэмжээ	-	-	31,945.80	31,552.90	32,841.20
				93.20%	67.30%	57.30%
4	Нийт зарцуулсан	9,357.50	12,374.60	13,126.40	12,206.70	24,651.20
5	Хуулийн хэрэгжилтийн дундаж хувь	36.5%	44.7%	38.3%	26%	43%

Нийт 12 аймаг, нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэдээгээр байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ангиллын зардлын 2022 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн 9.5 тэрбум төгрөгийн зарцуулалтын дэлгэрэнгүй мэдээнд үндэслэн төсвийн зарцуулалтыг дотор нь ангилан нэгтгэн үзэхэд 60 хувийг амьтан, ой, ус, газар, ургамлын арга хэмжээнд зарцуулсан, үлдсэн 40 хувийг зориулалт бусаар аялал жуулчлал, хог хаягдал цэвэрлэх, томилолт, шатахуун, бусад арга хэмжээнд зарцуулсан нийтлэг үр дүнтэй байна



**“Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль”-ийн хэрэгжилтийг
аймаг, нийслэл тус бүрээр (2019-2022 оны байдлаар)**

№	Аймгуудын нэр	Төвлөрүүлсэн орлогын дүн (сая.төг)				Хуулийн хэрэгжилтийн хувь			
		2019 он	2020 он	2021 он	2022 он	2019 он	2020 он	2021 он	2022 он
1	Архангай	597.08	2,882.53	1,986.21	2,035.26	74.8	35.1	18	80.1
2	Баян-Өлгий	1,359.20	340.41	1,233.08	1,081.92	1.2	4	0	35.5
3	Баянхонгор	1,219.06	999.04	2,173.03	2,906.13	16	18.5	8	72.1
4	Булган	15,533.15	15,412.39	18,838.38	19,658.96	43.5	54.1	47	53.3
5	Говь-Алтай	634.82	412.76	404.64	715.16	72.9	100.1	82	26.4
6	Говьсүмбэр	202.68	521.42	956.1	949.67	98.3	123.6	36	48.7
7	Дархан-уул	1,856.17	1,855.29	1,420.84	2,119.13	1.9	42.4	73	63.7
8	Дорноговь	1,082.37	2,718.78	2,294.53	4,523.93	31.1	24.2	27	93.1
9	Дорнод	4,039.96	4,746.39	4,239.04	4,317.12	59.6	39.3	28	62.8
10	Дундговь	670.06	629.73	936.19	1,468.23	37.6	30.3	34	21.1
11	Завхан	1,308.69	1,137.47	2,309.62	2,230.85	25.4	32.8	11	63.5
12	Орхон	20,373.82	19,790.68	11,908.97	21,398.53	34	7.6	22	33.5
13	Өвөрхангай	1,392.12	1,982.85	3,311.53	4,198.70	43.3	18.5	21	73.6
14	Өмнөговь	24,615.73	23,994.79	18,882.42	30,641.53	48.4	52.3	63	77.1
15	Сүхбаатар	1,173.03	641.83	2,020.28	1,989.86	13.3	117	20	97.5
16	Сэлэнгэ	2,405.57	8,871.93	10,840.71	11,439.18	40.3	13.2	6	17.7
17	Төв	6,438.54	4,865.23	6,610.68	7,506.67	36.7	32.1	23	20.9
18	Увс	997.42	491.59	1,074.37	1,293.97	85.1	102	21	108.2
19	Нийслэл	2,716.03	12,878.36	48,000.05	75,103.91	89.1	41.2	10	17.1
20	Ховд	1,482.48	355.72	1,651.34	2,610.71	19.4	178.6	14	31.8
21	Хөвсгөл	1,650.76	3,332.90	3,514.85	3,954.40	67	57.9	21	29.7
22	Хэнтий	2,121.97	3,267.52	5,300.60	5,385.52	55.4	15.8	11	24.8
Нийт		93,870.85	112,129.28	149,907.54	207,529.30	44.7	38.3	26	43



Дүгнэлт

1. Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардлын мэдээллийн сангийн (<https://eic.mn/finance/>) цахим системд аймаг нийслэлийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас мэдээг оруулахдаа Засаг даргын түвшинд мэдээг хянуулаагүй, тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулаагүй, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлын гүйцэтгэлийн мэдээг оруулаагүй, худал тайлагнасан нийтлэг зөрчил байна.
2. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн 2022 оны орлого 223.8 тэрбум төгрөг болж 2021 оноос 73.9 тэрбум төгрөгөөр өссөн, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ангиллын зардлыг Сангийн яамнаас 32.8 тэрбум төгрөгөөр тогтоосон боловч аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр зардлыг бүрэн батлаагүйгээс Монгол Улсын хэмжээнд 24.6 тэрбум төгрөг зарцуулсан буюу хуулийн хэрэгжилт 43 хувьтай байна.
3. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ангиллын зардлын зарцуулалтын 60.6 хувь нь амьтан, ой, ус, газар, ургамлын арга хэмжээнд, үлдсэн 40 хувийг аялал жуулчлал, хог хаягдал цэвэрлэх, томилолт, шатахуун зэрэг бусад арга хэмжээнд зарцуулагдсан байна.



Зөвлөмж

1. Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 4.1, 4.2, 4.3-т заасан тайланг [Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардлын мэдээллийн сангийн \(https://eic.mn/finance/\)](https://eic.mn/finance/) цахим системд үнэн зөв засаж оруулах тухай хугацаатай үүрэг даалгаврыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт хүргүүлэх;
2. Сангийн яамны байгалийн орчныг хамгаалах, нөхөн сэргээх ангиллын зардалд 31-33 тэрбум төгрөгөөр баталдаг хяналтын хэмжээг газрын төлбөрийн орлоготой уялдуулж 2024 оноос нэмэгдүүлэх талаар уулзалт хэлэлцүүлэг хийж, шийдвэрлэх;
3. [Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардлын мэдээллийн сангийн \(https://eic.mn/finance/\)](https://eic.mn/finance/) орлогын гүйцэтгэлийн мэдээг Татварын ерөнхий газрын цахим системд, зардлын гүйцэтгэлийн мэдээг Сангийн яамны төсвийн зарлагын мэдээллийн сангийн цахим системд холбож дундын мэдээллийн сантай болох зохицуулалтыг журамд өөрчлөлт оруулж шийдвэрлэх;
4. “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 2.5, 2.6, 2.7-д заасны дагуу 2023 оны орлого, зарлагын төлөвлөгөөг оруулаагүй аймаг, сумын Засаг дарга нарт хугацаатай үүрэг даалгавар өгөх;
5. Эдийн засгийн ангиллыг зөрчиж байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас хөрөнгө оруулалт болон зориулалтын бус хэлбэрээр зарцуулсан аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга нарыг Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4-т заасан “Төсвийн болон хандив, тусламжийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах”, Эрүүгийн хуулийн 22.8 дугаар зүйлд заасан “Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах” гэмт хэргийн шинжтэй гэж үзэн 2023 онд эрх бүхий байгууллагаар үргэлжлүүлэн шалгуулах, хамтран ажиллах.



БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

ᠪᠠᠶᠢᠭᠠᠯᠢ ᠣᠷᠴᠢᠨ,
ᠠᠶᠢᠯᠠᠯ ᠵᠠᠭᠤᠯᠠᠯ ᠵᠢᠰᠢᠯᠠᠯ ᠶ᠋ᠠᠮ

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД
БАЯРЛАЛАА

